

**“Эрдэнийн сан Субашид”-ын тайлбарын
нэгэн орчуулга**

Д.Заяабаатар (МУИС)

Д.Бадамдорж (МУИС)

Сажа бандид Гунгаажалцаны [Kun dga' rgyal mtsan, 1182-1251] “Эрдэнийн сан Субашид” [S. Subhāṣitaratnanidhi] нь Энэтхэгийн “Төрийн найман шастир” тэргүүтэн иргэний сургаалуудын үзэл санаа, уран сайхны шууд уламжлалаар бүтсэн ардын уран цэцэн үгийн түүвэр чанартай яруу найргийн бүтээл юм¹.

Энэхүү иргэний алдартай сургаалыг монгол хэлнээ удаа дараа орчуулсан бөгөөд монголчуудын ахуй амьдрал, зан заншил, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг гүн гүнзгий тусгахын хамт монгол төрх төлөвийг олж, шинэ хэлбэр агуулгаар баяжин төгөлдөржиж, өргөн хүрээнд түгэн дэлгэрчээ. Академич Ц.Дамдинсүрэнгийн тэмдэглэснээр, өнөө хир бидэнд мэдэгдээд байгаа “Субашид”-ын долоон монгол орчуулга байна². Үүнд:

1. Тарнич тойн Сономгарагийн (tarniči toyin Sonom gar_a) XII зууны эцэс үеийн орчуулга
2. Ойрдын Зая бандид Намхайжамцын (Zaya pandita Nam Kha' rgya mtso) XVII зууны үеийн орчуулга
3. Урадын мэргэн гэгээн Дамбалжалцаны (bstan pa rgyal mtsan) XVIII зууны үеийн орчуулга
4. Цахар гэвш Лувсанчүлтэмийн XVIII зууны үеийн орчуулга
5. Лувсанчүлтэмийн орчуулгыг засан найруулсан Буриадын эрдэмтэн Лувсанринчений (Ринчен Номтоев) хувилбар орчуулга
6. Лувсанринчений шинээр толгой холбосон нэгэн орчуулга

¹ Л.Хүрэлбаатар, *Энэтхэг, Төвд, Монголын сургаалын зохиолын хэлхээ холбоо*, Хэл зохиол судлал, XVIII боть, Хоёрдугаар бүлэг, Улаанбаатар, 1987, 193дугаар тал.

² *Монгол уран зохиолын тойм*, Хоёрдугаар дэвтэр (XVII-XVIII зууны үе), Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, Улаанбаатар, 1976, 353-354.

7. Дамбажалцаны орчуулгыг засан найруулсан Дана-гийн гэгээний (Dana-yin gegen) (Мэндгүй цорж хэмээх Төгөлдөрийн Галсанжамба) XIX зууны үеийн хувилбар орчуулга

“Субашид”-аас гадна түүний тайлбар гэж зохиол буй. Энэ нь “Субашид”-ын ухамж далд зарим бадаг хэсгийн утга санааг дөхөмчлөн ойлгуулах үүднээс түүний агуулгад зохин нийцэх элдэв үлгэрийн цоморлигоор чимсэн нэгэн иж бүтээл юм. Хэрэв сургаалын шүлгийг хүний амьдралын сурах бичиг гэж үзвээс түүний тайлбар өгүүллэг нь шүлэг найргийн ёгт далд утга санааг үлгэр домгоор үлгэрлэн өгүүлсэн унших бичиг гэж ойлгож болно³.

“Субашид”-ын тайлбарын талаар нэлээд дэлгэрэнгүй мэдээ баримтыг Ц.Дамдинсүрэн гуай “Монгол уран зохиолын тойм” хэмээх бүтээлдээ дурджээ.

“Субашидийн” тайлбар төвд хэлэн дээр лав хоёр байхыг бид үзсэн билээ. Хамгийн анхны хамгийн найдвартай тайлбар бол XIII зууны үед Ринчинбал хэмээх хүний зохиосон бөгөөд Сажса бандид Гунгаажалцаны дотно шавь Мардон Чойжсал хэмээх хүний найруулан зассан тайлбар болно. Энэ номын нэр нь: legs-par bshad-pa rin-po che'i gter-gyi 'grel-pa (Сайтар номлосон Эрдэнийн сангийн тайлбар). Нөгөө тайлбарын нэр нь: legs-par bshad-pa rin-po che'i gter zhes bya-ba bstan bcos 'grel-ba dang bcas-ba (Сайтар номлосон Эрдэнийн сан нэрт шастирын гол судар ба үлгэр тайлбар сэлт). Энэхүү хоёр тайлбар нь монгол хэлнээ хэд орчуулагдсан байна. “Субашидийн” эдгээр хоёр төвд тайлбарын дотор “Рамаянын” товч агуулга байх тул мөн тайлбаруудын монгол орчуулгад “Рамаянын” товч агуулга багтаж орсон нь мэдээж хэрэг билээ. Ринчинбалын зохиосон “Субашидийн тайлбар”-ыг ойрдын Намхайжамцын шавь Гарсан XVII зууны үед орчуулсан нь тод үсгээр байдаг⁴. Түүний бас нэг монгол орчуулгыг XVII зууны орчим Тайгун Таюн шигу гүүш хийжээ⁵. “Субашидийн” нөгөө тайлбар “Гол судар, үлгэр тайлбар сэлт” хэмээхийг XVII зууны орчим Мэргэн дайчины дуртгасан ёсоор Чойжсамц орчуулжээ. Энэ монгол орчуулга Чойжилсүрэн багшид бий.

³ Д.Цэрэнсодном, *Монголын бурханы шашны уран зохиол*, Улаанбаатар, 1997, 304-305.

⁴ Библиотека Восточного факультета ЛГУ, рукописный фонд, Calm. D-19. Q-575.

Уг эх А.Г.Сазыкины бүртгэлд ороогүй байна. А.Г.Сазыкин, *Каталог монгольких рукописей и ксилографов ИВАН, СССР*, Том I, Москва, 1988.

⁵ W.Heissig, *Mongolische Handschriften, Blockdrucke, Landkarten*, Wiesbaden, 1961, s. 32.

Бас нэг хувь Ц.Дамдинсүрэн бий. Ленинградын Их Сургуулийн Дорнодахны факультетийн номын санд бас нэг дутуу хувь бий⁶.

Монголын эрдэмтэн нар "Субашид"-ын тайлбарыг зөвхөн орчуулсан төдий биш, өөрсдөө төвд тайлбаруудын үндсэн дээр нэмж засаж зохиож байв. Үүний жишээнд Цахар гэвш Лувсанчүлтэм 1779 онд зохиож модон бараар хэвлүүлсэн "Сайн номлолт эрдэнийн сан Субашидийн тайлбар чандманийн түлхүүр", Номтын Ринчиний зохиосон "Сайн номлолт эрдэнийн сан субашидийн тайлбар чандманийн түлхүүр" зэрэг тайлбарыг дурдаж болно⁷.

Өмнө дурдсан тайлбарын орчуулгаас өргөн дэлгэр тархсан нь Цахар гэвш Лувсанчүлтэмийн "Сайн номлолт эрдэнийн сан Субашидийн тайлбар чандманийн түлхүүр" юм.

Саяхан бид, Хэл Иргэншлийн Дээд Сургуулийн Сударын танхимд хадгалагдаж байсан "Субашид"-ийн тайлбарын нэгэн орчуулгыг олж үзлээ.

"*Sayitur nomlaysan erdinij=erdeni-yin sang neretü šastir-un tayilburi kemegdekü neretü sudur orosiba!*" (*ᠰᠠᠶᠢᠲᠤᠷ ᠨᠣᠮᠯᠠᠶᠰᠠᠨ ᠡᠷᠳᠢᠨᠢᠵᠢ=ᠡᠷᠳᠢᠨᠢ-ᠶᠢᠨ ᠰᠠᠩ ᠨᠡᠷᠡᠲᠦ ᠱᠠᠰᠢᠷ-ᠤᠨ ᠲᠠᠶᠢᠯᠢᠪᠦᠷᠢ ᠬᠡᠮᠡᠭᠢᠳᠡᠬᠦ ᠨᠡᠷᠡᠲᠦ ᠰᠤᠳᠤᠷ ᠣᠷᠣᠰᠢᠪᠠ!*) гэж гарчигласан энэхүү хулсан үзгийн эх нь 21x7 см хэмжээтэй зузаавтар шаргал цаасан дээр хүрэн бэхээр хос шугам татаж хашсан 30x5.1 см хэмжээ бүхий хайрцагт 21 мөрөөр хичээнгүйлэн бичсэн, 91 хуудастай судар юм. Хуудасны ар талд дугаар тавиагүй бөгөөд үсгийн хэв нь нэгэн жигд, хар бэхээр хулсан үзгийг дарж бичсэн, гаргац тод эх ажээ. Шүлгийн хэсгийг бүдэг хүрэн өнгөөр зурж тодотгосон нь хожмын нэмэлт бололтой.

Үсгийн хэв, тиг зурлага, бичлэгийн төрх байдлын нүднээ тусах хэлбэрээс XVII зууны үеийн хуулбар болов уу гэсэн урьдчилсан таамаг хэлж болох байна. Академич Ц.Дамдинсүрэн, доктор Л.Хүрэлбаатар нар Чойжамцын орчуулгыг XVII зууны үед хамаатуулан дурджээ⁸.

Төгсгөлийн үгийг галиглан сийрүүлбэл:

{89b...} yirtinčü-yin yosun dayaju günga_a rgyal mcan (ᠶᠢᠷᠲᠢᠨᠴᠦ-ᠶᠢᠨ ᠶᠣᠰᠤᠨ ᠳᠠᠶᠠᠵᠤ ᠭᠦᠩᠭ᠋᠎ᠠ ᠷᠭᠠᠯ ᠮᠴᠠᠨ) bi ber degedü ene nom-i üjegülbei. sonusuysan dalai-yin tib-eče sayitur egüdүged, sayin oyutan-u luusun [=luus-un] erketü ber oyuyata ejelegsen, tegüs čoy_tu sayin nomlal-un erdeni-yin sang anu, tungyalay biligten-ü oyun-u sang-yi [sang-i] {90a} degürgeküi kiged merged-ün kedün küsel-i бүтүгекүй-yin tula, sagyalу-ud-un ayay q_a tekimlig gün

⁶ Ц.Дамдинсүрэн, *Монгол уран зохиолын тойм*, Эрхлэн хэвлүүлсэн Ж.Бат-Ирээдүй, Улаанбаатар, 1999, 164-166.

⁷ Л.Хүрэлбаатар, *Монгол орчуулгын товчоон*, Улаанбаатар, 1995, 90дүгээр тал.

⁸ Ц.Дамдинсүрэн, *Монгол уран зохиолын тойм*, Эрхлэн хэвлүүлсэн Ж.Бат-Ирээдүй, Улаанбаатар, 1999, 164-166; Л.Хүрэлбаатар, *Монгол орчуулгын товчоон*, Улаанбаатар, 1995, 90дүгээр тал.

dga_a rgyal mcan dbal mzung bô (ཀུན་དགའ་རྒྱལ་མཚན་དཔལ་བསང་པོ།) neretü boyda ber buyan_tu sedkil-iyer sayitur belgedejü qamuy jug-tegen geyigül_ün [=geyigülün] üiledkü-yin tula, egüni [=egün-i] ilyan jokiyabai. egünče [=egün-eče] boluysan gkir-ügei buyan anu sine[=sin_e]-yin sara metü tungyalay beligten-ü [=biligten-ü] oyun-u gümede čečeg delgerekü boltuyai. qotala medegdekün-e sayitur sudulju qamuy-i ayiladuyči burqan-u qutuy-i tuyulqu-yin tula, bi ber ene sastir-i yi [=šastir-i] tuyuluysan burqan-u qutuy-i olqu-yin tula jokiyaysan bülüge. ene sastir [=šastir] jokiyaysan orun anu, umar_a jug-ün časutan-u orun enedkeg-ün večir_tü [=včir] orun-ača inaysi jaγun bere-yin yaγar-a töbed-ün gzung las

sdôda gyômba neretü yaγar-taki čoy-tu sa skyay_a (སྐྱེ) neretü yeke buqar⁹ keyid-tür manjusiri-yin adistid-bar [=adistid-iyar] oyun-u lingqu_a delgeregsen {90b} tere boyda ber, dayun uqayan ba silyadaγ oyun-u sastir-i [=šastir-i] terigüten olan sastir [=šastir] kiged, burqan-u sayin jarliy-nuyud-i [=jarliy-ud-i] doturban [=dotur_a-ban] baytayaysan-iyar isi uqayan ba, ubadis-un onisun-tur [=onisun-dur] uqayan inu geyigsen-ü tula, nomlaqui kiged tuyurbiqui ba temečeldeküi kiged, bisalyaqui terigüten-tür [=terigüten-dür] mergen sagyalij-ud-un [=] ayay q_a tekimlig

gün dga_a rgyal mcan dbal bzang bô (ཀུན་དགའ་རྒྱལ་མཚན་དཔལ་བསང་པོ།) kemekü yeke boyda ber tegüs čoytu sa skyay_a neretü yeke sūme-tür [=süm_e-dür] nayiryulun [=nayirayulun] jokiyaysan-i tegüsbe. egüni [egün-i] čü sa skyay-a bañačin-ü jokiyaysan-u ijaγur γoul sudur-iyar erkilejü, tayilburi terigüten-eče čimeglen nemejü mongyolčilan orčiyulbai. erdem_ten [=erdemten] merged ber jasan soyurq_a. erelkeg merged ber endegürejü buruyu boluyqu boluyjai, ergičegül_ün [=ergičegülün] sayitur sinjilebesü sayin bülüge. erkin oyutu mergen dayičing ber, ene sastir-i [=šastir-i] orčiyul kemegsen-iyer qotala-yin dalai yeke nom-un küriyen-tür [=küriyen-

dür], egel dooradu côs rgyamcô (ཚོས་རྒྱལ་མཚན།) neretü dgecül ber, erke ügei orčiyuluysan buyan-iyar eke boluysan qamuy amitan bügüdeger burqan-u qutuy-i olqu boltuyai. mangha lam, bavangdu,

Төгсгөлийн үгэнд тэмдэглэсэн "Эрхин оюут Мэргэн дайчин бээр энэ шастирьыг орчуул хэмээснээр Хотолын далай их номын хүрээнд эгэл доорд Чойжамц нэрт гэгцэл бээр эрхгүй орчуулсан буянаар эх болсон хамаг амьтан бүгдээр хутгийг олох болтугай" гэсэн хэсгээс уг тайлбарыг Чойжамц хэмээх номын хишигтэн орчуулсныг даруй мэдэж болно. Энэ хүн бол Ц.Дамдинсүрэн гуайн дурдсан "Субашид"-ийн нөгөө тайлбар "Гол судар, үлгэр тайлбар сэлт" хэмээхийг XVII зууны орчим Мэргэн дайчины дуртгасан ёсоор" орчуулсан Чойжамц мөн.

⁹ Сүм хийд, бухар хийд. Sečenčoytu, *Mongγol üges-ün ijaγur-un toli*, ОМАККQ, 1987, 785дугаар тал; согд. Вуγг (<sam. viħara): мо.б. buqar; Лам нарын хуран суух сүм орон хийд, хийд. О.Сүхбаатар, *Монгол хэлний харь үгийн толь*, Улаанбаатар, 1997, 47дугаар тал.

Уг судрын төгсгөлийн үгийг академич Ц.Дамдинсүрэн болон Ардын багш Д.Чойжилсүрэнд байсан Чойжамцын орчуулгын төгсгөлийн үгтэй харгуулан үзвэл, үг үсгийн зөрөө байх боловч үндсэн агуулга нь таарч байна¹⁰. Өөрөөр хэлбэл, уг судрууд нь нэгэн эхийн хувилбарууд ажээ. Чухам аль нь түрүү үеийнх болохыг одоогоор бат нут хэлэх боломжгүй бөгөөд тэдгээр эхийг харьцуулан нягталсны дараа тодлох зүйл бүлгээ.


“Эрдэнийн сан Субашид”-ын тайлбарын гэцэл Чойжамцын орчуулга нь:

- Зөвхөн тайлбар үлгэр бүхий бадгийг түүн орчуулсан боловч бусдаас ялгарах онцлогтой бие даасан орчуулга болсон учир тухайн хэсгийг харьцуулан судлахад чухал баримт хэрэглэхүүн болно.
- Бид Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Сайн номлолт эрдэнийн сан Субашидийн тайлбар чандманийн түлхүүр” хэмээх үлгэрийн цоморлигийг сайн мэдэх билээ. Тэгвэл үүнтэй харьцуулан шинжилж, онцлог ялгааг тодруулах бас нэгэн хэрэглэхүүн нь Чойжамцын орчуулга юм. Ц.Дамдинсүрэн гуайн хэвлүүлсэн Цахар гэвшийн тайлбартай мөчид харгуулж, хэдэн зүйл онцлогийг ажиглав.
 - Цахар гэвшийн тайлбар дахь үлгэрийн цоморлигтой утга агуулга ерөнхийдөө таарах боловч үг хэллэг, найруулгын хувьд эрс өөр байна.
 - Цахар гэвшийн тайлбарт буй зарим бадгийг орхигдуулжээ.
 - Цахар гэвшийн тайлбарлаагүй зарим бадгийг орчуулж, тайлбар үлгэрийг хавсаргажээ.
- Монгол судар ном, орчуулгын уламжлалд үнэ цэнтэй сурвалж болно. Ялангуяа шашны үзэл номлол, утга агуулгаас ангид тусгаар дан гагц иргэний сургаал, түүний тайлбар үлгэрийн орчуулга учраас ховор нандин дурсгал болох юм.

Эцэст уншигч танаа сонордуулахад, уг сурвалжийн эхийг гэрэл зургаар буулгаж, галиг, товч тайлбарын хамт хэвлүүлэхээр зэхэж буй билээ.

¹⁰ Г.Билгүүдэй, Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол номын бүртгэл, I боть, Улаанбаатар, 1998, 36-37.

Уг номд Дамдинсүрэн гуайд байсан Чойжамцын орчуулгын төгсгөлийн үгийг нэлээд дэлгэрэнгүй оруулжээ. Мөн Чойжилсүрэн багшид байсан орчуулгын төгсгөлийн үгээс хэсэгчлэн буулгасан академич Ц.Дамдинсүрэнгийн гар бичмэлийг хавсаргасан байна.



Судрын төгсгөлийн хуудас
"Эрдэнийн сан Субашид"-ын тайлбарын гэцэл Чойжамцын орчуулга